



ШУДАРГА ЁС,
ХӨГЖИЛ
ДЭВШИЛД

2022 оны ХАСХОМ-ийг шинэчлэн мөдүүлэх тухай

Монгол Улсын Авлигатай тэмцэх газар,
Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс
УБ хот, 2023.01.10





ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц- 2005.10.27
- Авлигын эсрэг хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” УИХ-ын 2016.11.03-ны өдрийн 51 дүгээр тогтоол
- УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012.04.25-ны өдрийн 05 дугаар тогтоол, /2014.12.23-ны өдрийн 20, 2017.01.03-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор тус тус нэмэлт өөрчлөлт орсон./

Хавсралт-1. /Албан тушаалтны ХАСХОМ-ийг бүртгэх, хянах, хадгалах журам/

Хавсралт-2. /Албан тушаалтны ... оны ХАСХОМ/

Хавсралт-3. /Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ/

Хавсралт-4. /Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл/

Хавсралт-5. /ХАСХОМ гаргах албан тушаалтны жагсаалт/ /УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2014.12.23-ны өдрийн 20 дугаар тогтоолоор нэмэлт орсон/

Хавсралт-6. /Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө орлогын мэдүүлэг/

Хавсралт-7. Баталгааны маягт

- “Журам батлах тухай” АТГ-ын даргын 2018.11.21-ний өдрийн А/121 дүгээр тушаал

Хавсралт: /Албан тушаалтны ХАСХОМ-ийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ-ы үйл ажиллагааны журам/



ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- **“Маягт, заавар батлах тухай” АТГ-ын даргын 2018.05.21-ний өдрийн А/45 дугаар тушаал** /ҮСХ-ны даргын 2018.05.15-ны өдрийн А/51-р тушаалаар зөвшөөрснөөр/

Хавсралт: /“Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн 20.... оны тайлан”/

- **“Маягт, заавар батлах тухай” АТГ-ын даргын 2012.06.13-ны өдрийн 91 дүгээр тушаал** (АТГ-ын даргын 2017.01.03-ны өдрийн А/129, 2018.12.25-ны өдрийн А/148 дугаар тушаалаар тус тус нэмэлт, өөрчлөлт орсон.)

Хавсралт-1 /Албан тушаалтны ... оны Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуй мэдээ/

Хавсралт-2 /Албан тушаалтны ... оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн хураангуй мэдээ/

Хавсралт-3 /Мэдүүлэг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан, хугацаа хожимдуулсан албан тушаалтны нэрсийн жагсаалт/

Хавсралт-4 /Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэл/

Хавсралт-5 /Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүртгэл/

Хавсралт-6 /Мэдэгдэл, тайлбар, мэдээлэл, тэдгээрийн шийдвэрлэлтийн бүртгэл/

Хавсралт-7 /ХАСХОМ гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдээс оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан тухай болон өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаарх урьдчилсан мэдүүлгийн бүртгэл/

Хавсралт-8 /Албан тушаалтны мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарын талаар мэдээлэл өгсөн тухай бүртгэл/

- **“Журам батлах тухай” АТГ-ын даргын 2018.11.14-ний өдрийн А/122 дугаар тушаал**

Хавсралт-1 /Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар иргэдэд мэдээлэл өгөх журам/

Хавсралт-2 /Мэдээлэл авах хүсэлт гаргах маягт/

Хавсралт-3 /Албан тушаалтны ... оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуй мэдээлэл/

Хавсралт-4 /Албан тушаалтны ... оны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн хураангуй мэдээлэл/




**Авлигын эсрэг
хуульд заасан
8 төрлийн
хориглолт**

- Албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс нөлөөлөх.
- Бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;
- Албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;
- Төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;
- Албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;
- Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;
- Албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;
- Үндэслэлгүйгээр хөрөнгөжих;



Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан 13 төрлийн хориглолт, хязгаарлалт

1. Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон хориглолт
2. Оффшор бүсэд данс, хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт
3. Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт
4. Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох
5. Сурталчилгаатай холбогдсон хязгаарлалт
6. Төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт
7. Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт
8. Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт
9. Хандив авахтай холбогдсон хязгаарлалт
10. Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт
11. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт
12. Албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хязгаарлалт
13. Бусад орлогын хязгаарлалт



МЭДҮҮЛЭГ


ХАСУМ

ХАСХОМ

**Мэдэгдэл,
тайлбар**

**Сонгуульд нэр
дэвшигчийн ХОМ**

Хяналт шалгалтын чиг үүрэг/төрөл/*



Нийтийн албанд
томилогдохоор нэр дэвшсэн
этгээдийн **ХАСУМ**-ийг
хянан шалгах

Хуулийн үйлчлэлд
хамрагдах албан
тушаалтны **ХАСХОМ**-ийг
хянан шалгах

Иргэн, аж ахуйн нэгж
байгууллагаас ирүүлсэн
албан тушаалтны
авлига, ашиг сонирхлын
зөрчилтэй асуудлыг
хянан шалгах

**Дээрх 3 төрлийн хяналт шалгалтыг АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс хэрэгжүүлдэг.*

ЭБАТ нь нэрсийн жагсаалтыг гаргахдаа:

ХАСХОМ гаргавал зохих албан тушаалтны Нэрсийн жагсаалтыг гаргахдаа Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасныг баримтлана.

Тухайн
байгууллагын
бүтэц орон тоог
баталсан
шийдвэр

Ажлын чиг
үүргийг зааж
баталсан албан
тушаалын
тодорхойлолт
болон гэрээ

Тухайн албан
тушаалын төрөл,
ангилал, зэрэглэл

Авлига, ашиг
сонирхлын
зөрчилд өртөх
эрсдэл



МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧ



ТЗ- төрийн захиргааны албан тушаалын ТЗ-6, түүнээс дээших албан тушаалтнууд хамаарна. 3Г-ын 2019 оны 275 (3Г-ын 2020 оны 184, 2022 оны 194-р тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон)

- УИХ-ын 2019 оны 18-р тогтоол (2020 оны 41, 2020 оны 51, 2021 оны 06, 2021 оны 18, 2021 оны 70, 2021 оны 73 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан): Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ахлах, эрхэлсэн, тэргүүн түшмэл гэсэн ангиллын АА1-АА8 зэрэглэл хамаарна /дэс түшмэл АА9-АА11 хамаарахгүй/

ТҮ- төрийн үйлчилгээний албан тушаал

- **3Г-ын 2019 оны 25-р тогтоол**

1-р хавсралт ТҮЭМ6-ТҮЭМ9 "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл" (1-р хавсралтад 3Г-ын 2019 оны 276, 2020 оны 184-р тогтоолоор тус тус нэмэлт орсон)

2-р хавсралт ТҮБД4-ТҮБД5: "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл"

3-р хавсралт ТҮМБ6-ТҮМБ7 "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл"

- **3Г-ын 2019 оны 276-р тогтоол:**

1-р хавсралт ТҮШУ4-ТҮШУ7 "ШУ-ны салбарын ТҮ-ний албан тушаалын зэрэглэл" (1-р хавсралтад 2021 оны 165-р тогтоолоор нэмэлт орсон)

2-р хавсралт ТҮСУ5-ТҮСУ7 "Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл"

3-р хавсралт ТҮ9-ТҮ12 "ТҮ-ний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл"

Мэдүүлэг гаргагчийн үүрэг



ХАСХОМ



**Шинээр томилогдсон,
эсхүл сонгогдсон
/30 хоногт/**



**Шинэчлэн
/жил бүрийн 2/15-
ны дотор**



**ХОМ-т их хэмжээний
өөрчлөлт орсон
/30 хоногт/**

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ
2023.01.01-нээс 550 мянган төгрөг болсон
тул ХОМ-ийн их хэмжээ 137.500.000
төгрөг, түүнээс дээш

ХАСХОМ-ийн цахим системд нэвтрэх

The screenshot shows a web browser window with the address bar displaying "meduuleg.iaac.mn". The page title is "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүрдүүлэлтийн систем". The page contains a login form with the following elements:

- Input field: "Имэйл хаягаа оруул" (Enter email address)
- Input field: "Нууц үгээ оруул" (Enter password)
- Link: "Нууц үг сэргээх холбоос" (Forgot password link)
- Buttons: "Нэвтрэх" (Login) and "Арилгах" (Cancel)

Callouts from the right side of the image point to the input fields:

- Callout 1: "Цахимд бүртгүүлсэн Имэйл хаягаа бичнэ" (Write the email address registered in the system)
- Callout 2: "Цахимд бүртгүүлсэн Имэйл хаягаар ирсэн нууц үг" (Password received from the email address registered in the system)
- Callout 3: "Нууц үг сэргээх холбоос" (Forgot password link)

- Мэдүүлэг гаргагч байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд баталгаатай /имэйл/ хаягийг өгнө ;
- Мэдүүлэг гаргагчийн цахимд бүртгүүлсэн /и-мэйл/ хаягийг ашиглагдахгүй болсон бол байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд баталгаатай /и-мэйл/ хаягийг өгч засварлуулна;
- Хөрөнгө орлогын мэдүүлгийн системд нэвтрэх "Нууц үг" -ийг мартсан бол "Нууц үг сэргээх холбоос" руу орно.



Мэдүүлэг гаргагч,
түүний гэр бүлийн
байдал:

- Мэдүүлэг гаргагч
- Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал

Хувийн ашиг сонирхол:

- Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд
- Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд
- Гишүүнчлэл, хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн
- Төлөөлөл хэрэгжүүлсэн байдал
- Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлал, хандив, туслалцаа, хөнгөлөлт
- Урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан байдал

Хөрөнгө, орлого:

Орлого

- Орлого

Хөрөнгө, зээл

- Орон сууц, барилга байгууламж
- Тээврийн хэрэгсэл
- Мал аж ахуй
- Газар
- Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйл
- Хадгаламж, бэлэн мөнгө, хувийн харилцах болон төлбөрийн данс, картны үлдэгдэл
- Авлага
- Зээл
- Компани, нөхөрлөл, хоршоонд оруулсан хөрөнгө оруулалт
- Эрх, патент, тусгай зөвшөөрөл



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ЗАГВАР ЖИШЭЭ №1

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны
2012 оны 05-р тогтоолын 2-р хавсралт

АЛБАН ТУШААЛТНЫ 2017 ОНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ

Нэг. Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал:

1.1. Мэдүүлэг гаргагч																						
Ургийн овог: Боржигон	Эцэг/эхийн нэр: Дорж	Нэр: Болдбаяр																				
Регистрийн дугаар:	Иргэний үнэмлэхийн дугаар:																					
<table><tr><td>A</td><td>Ю</td><td>7</td><td>1</td><td>1</td><td>1</td><td>1</td><td>6</td><td>7</td><td>0</td></tr></table>	A	Ю	7	1	1	1	1	6	7	0	<table><tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr></table>											
A	Ю	7	1	1	1	1	6	7	0													
Оршин суугаа газрын хаяг: БГД, 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот	Гар утас: 9999-9999 Ажлын утас: 7011-2468 Гэрийн утас: 7011-2469	Цахим шуудангийн хаяг: Bayar_99@gmail.com																				
Боловсрол, мэргэжил: Дээд, эрх зүйч	Байгууллагын нэр: Байгаль орчин, ногоон хөгжлийн яам																					
Төрсөн газар: Архангай, Эрдэнэбулган сум, эмнэлэг	Газар, хэлтэс, тасаг, алба: Төрийн захиргаа, удирдлагын газар																					
Үндсэн харьяа: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг	Албан тушаал: Ахлах мэргэжилтэн																					
Сүүлийн хоёр жил ажилласан байгууллага, албан тушаал: Авто замын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн																						
Мэдүүлэг гаргах үндэслэл: ☒ тэмдэглэгээ хийнэ.	Тухайн албан тушаалд томилогдсон, сонгогдсон огноо:																					
Шинээр томилогдсон, Сонгогдсон	☐																					
Шинэчлэн гаргасан	☒																					
Их хэмжээний өөрчлөлт	☐																					
		2017 он 05 сар 15 өдөр																				

1.2. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал

Гэр бүлийн байдал	Эцэг /эх/-ийн нэр, нэр	Регистрийн дугаар	Төрсөн газар, үндсэн харьяа	Эрхэлж байгаа ажил, албан тушаал	Ажиллаж байгаа байгууллага, сурч байгаа сургууль, оршин суугаа газрын хаяг
Эхнэр, нөхөр, хамтран амьдрагч	Очирбатын Энхцэцэг	Ш372060120	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1 дүгээр төрөх, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг	“Улам-Ундрах” ХХК-ийн ерөнхий захирал	Ажлын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Маргад центр 545 тоот. Гэрийн хаяг: Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот.
Хүүхэд	Баярын Тэмүүлэн	УХ94041210	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Эх нялхас эрдэм шинжилгээний төв	ОХУ-ын Нисэхийн дээд сургуульд оюутан	Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот.
	Баярын Хүслэн	УХ06291020	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Эх нялхас эрдэм шинжилгээний төв	Баянгол дүүргийн 13-р дунд сургуульд сурагч	Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот.
Эцэг	--	--	--	--	--
Эх	--	--	--	--	--

Тайлбар: Хамт амьдарч байгаа болон өрхийн бүртгэлд бүртгэлтэй эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, эцэг, эхийг бичнэ.

Гарч буй нийтлэг зөрчлүүд:

- Өрх тусгаарласан хүүхдүүдийг мэдүүлдэг.
- Өрхийн бүртгэлд бүртгэлтэй гадаадад суралцдаг хүүхдүүдийг мэдүүлдэггүй.
- Ажил эрхлэлтийн байдал мэдүүлдэггүй.
- Регистрийн дугаар буруу мэдүүлдэг.

Хоёр. Хувийн ашиг сонирхол

2.1. Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд

Эцэг /эх/-ийн нэр, нэр	Ямар хамааралтай болох	Ажиллаж байгаа /байсан/ байгууллага, албан тушаал	Бизнес, үйл ажиллагааны чиглэл	Төрсөн газар, үндсэн харьяа
Гомбосүрэнгийн Батцэцэг	Эх	Өндөр насны тэтгэвэрт	--	Завхан аймаг, Тосонцэнгэл сум. Архангай аймаг, Эрдэнэбулган сум.
Гаадангын Очирбат	Хадам эцэг	“ААА” ХХК-ийн ерөнхий захирал	Барилга, зам гүүр	Булган аймаг, Булган сум. УБ хот, Баянзүрх дүүрэг.
Эрдэнэбатын Цэцэгмаа	Хадам эх	Цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байсан. 2016 онд өндөр насны тэтгэвэрт гарсан.	--	Төв аймаг, Эрдэнэсант сум. УБ хот, Баянзүрх дүүрэг.
Доржийн Болдсайхан	Ах	Оюуны өмчийн газарт мэргэжилтэн	Төрийн байгууллага	Архангай аймаг, Эрдэнэбулган сум. УБ хот, Баянзүрх дүүрэг.
Доржийн Баяртүвшин	Дүү	2014-2016 онд Соёл урлагийн хороонд мэргэжилтнээр ажиллаж байсан, одоогоор ажилгүй.	--	Архангай аймаг, Эрдэнэбулган сум. УБ хот, Баянзүрх дүүрэг.
Очирбатын Гэрэл	Эхнэрийн эгч	Бүгд Найрамдах Солонгос Улсад ажиллаж амьдардаг.	БНСУ-д оёдлын үйлдвэрт ажилладаг.	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг УБ хот, Баянзүрх дүүрэг.
Очирбатын Бат	Эхнэрийн дүү	МУИС-н Хууль зүйн сургуулийн 3-р курсын оюутан.	Боловсрол	УБ хот, Баянзүрх дүүрэг. УБ хот, Хан-Уул дүүрэг

Тайлбар: Нийтийн албан тушаалтны эрхлэх асуудлын хүрээ, шууд болон шууд бус нөлөөлөх боломжтой байгууллагад харьяалалтай болон хамааралтай ажил эрхэлж байгаа /байсан/ өрх тусгаарласан эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, эхнэр /нөхөр/, хамтран амьдрагчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүг бичнэ.

АСЗХ-ийн 3.1.5: “Хамаарал бүхий этгээд” гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг хэлнэ.

2.2. Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд

Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Ямар харилцаатай /байсан/ болох /хуулийн этгээд бол ямар хамааралтай болох/	Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Байгууллага. ажил, албан тушаал /Эрхэлж байгаа /байсан/ үйл ажиллагааны төрөл/	Тайлбар
“Улам-Ундрах” ХХК	Хувь эзэмшигч, үүсгэн байгуулагч	Гадаад, дотоод худалдаа, хүнсний үйлдвэрлэл	—	2006 онд эхнэрийн хамтаар үүсгэн байгуулсан.
О.Бат	Эхнэрийн дүү	Автомашин худалдаа	Япон улсаас хамтарч автомашин импортоор оруулж ирж борлуулж ашиг олдог.	2010 оноос эхлэн одоог хүртэл хамтарч ажиллаж байна.
Д.Чулуун	Найз	Жимс, хүнсний ногоо тариалах	Өлзийт хороололд хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарьж борлуулдаг.	2008 оноос эхлэн одоог хүртэл хамтарч ажиллаж байна.

Тайлбар: Нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн талаар бичнэ.

2.3. Гишүүнчлэл, хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн

№	Хаана, ямар байгууллагад харьяалалтай болох	Албан тушаал, үүсгэн байгуулагч, гишүүн, дэмжигчийн аль нь болох	Үйл ажиллагааны чиглэл, зорилго	Тайлбар
1	УБ хот дахь Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутгийн зөвлөл	Гишүүн	Орон нутгийг хөгжүүлэх	2012 онд зөвлөлийн гишүүн болсон.
2	Монголын Хөл бөмбөгийн холбоо	Удирдах зөвлөлийн гишүүн /байсан/	Спортыг хөгжүүлэх	2009-2014 онд гишүүнээр ажиллаж байсан.

Тайлбар: Холбоо, нэгдэл, хөдөлгөөн, нутгийн зөвлөлийн тэргүүн, гишүүн, нам, улс төр, олон нийтийн байгууллагын гишүүнчлэлд байсан болон байгаа талаар бичнэ.

2.4. Төлөөлөл хэрэгжүүлсэн байдал

№	Хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Төлөөллийг хаана, хэзээ, хэрхэн хэрэгжүүлсэн	Тайлбар
1	Төрсөн ах Д.Баярсайхан	--	2015 онд төрсөн ах Д.Баярсайханы өмчлөлийн орон сууцыг худалдан борлуулахад итгэмжлэлээр төлөөлсөн	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Шинэ өглөө хотхоны 503 тоот 3 өрөө орон сууцыг худалдсан.

Тайлбар: Хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөн тодорхой үйл ажиллагаа, харилцаанд оролцсон талаар бичнэ.

2.5. Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлал, хандив, туслалцаа, хөнгөлөлт

№	Эх сурвалжийн нэр, хаяг	Бэлэг,үйлчилгээ, өв залгамжлалын төрөл	Хандив, туслалцаа, хөнгөлөлтийн зориулалт	Үнэлгээ /төгрөг/	Тайлбар
1	Эцэг М.Дорж /өв залгамжлал/	Өв залгамжлалаар Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот орон сууц	--	80.000.000	Эцэг М.Доржоос өв залгамжлалаар авсан
2	Авто тээврийн газар /туслалцаа/	Бэлэн мөнгө	Орон сууцны нөхцөл сайжруулах	10 000 000	Байгууллагаас 2015 онд орон сууцны нөхцөл сайжруулах
	Нийт дүн			92 000 000	

Тайлбар: Тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас дээш хэмжээний бэлэг, үйлчилгээ авсныг бичнэ. Хууль ёсны өв залгамжлалаар хүлээн авсан буюу авах хөрөнгийн талаар мэдүүлнэ.

2.6. Урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан байдал

№	Мэдүүлэг, мэдэгдлийн нэр	Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хэзээ, хаана, хэнд гаргасан /Байгууллага, албан тушаалтан/	Гаргах болсон шалтгаан, нөхцөл	Товч утга
1	Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл	Авто замын газрын Хуулийн зөвлөх Д.Намсрайжавт 2017.06.09	Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахдаа гаргасан.	Авто замын газраас зарласан тендерт үнэлгээний хорооны гишүүнээр оролцохдоо ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн.
2	Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг	Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд 2017.09.20-ны өдөр гаргасан	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшихдээ гаргасан.	Хувийн ашиг сонирхлын байдлыг мэдүүлсэн

Тайлбар: Тухайн жилд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшихдээ гаргасан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан тухай бичнэ.

3.1. Орлого		/төгрөгөөр/		
№	Орлогын төрөл	Орлогын дүн		Орлогын эх үүсвэр
		өөрийн	гэр бүлийн гүшүүний	
5	Хөрөнгө борлуулсны орлого /Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хувьцаа борлуулсны орлого/	300 000	-	“ТТТ” ХК-ны 500 ш хувьцаа борлуулсан
		-	35 265 000	Япон улсаас оруулж ирсэн Ниссан Тийда, Тоёота Гранд Марк II, Тоёота Витз маркийн (номергүй) авто машинуудыг борлуулсан
		3 600 000	-	30 толгой хонь борлуулсан.
6	Хандивын орлого /бусдаас авсан мөнгөн хандив, тусламж/	10 000 000	-	Орон сууцны нөхцөл сайжруулах
7	Бусад орлого /шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, бүтээгдэхүүний ашигтай загвар зохион бүтээх, спорт, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого, шагнал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, төрөөс олгож байгаа бүх төрлийн мөнгөн тэтгэмжийн орлого /	6 120 000	-	Малын ашиг шимийн (ноолуур, мах) орлого
		-	2 514 000	БНСУ-д ажилладаг хадам эгчээс 2000 ам.доллар өгсөн
		924 350	-	шинэ орон сууц худалдан авсны татварын буцаан олголт
		-	120 000	Хүүхдийн мөнгө
		126 000	378 000	Эх орны хишиг
8	Нийт дүн	56 300 617	76 127 273	

Тайлбар: Тайлант хугацаанд олсон орлогыг бичнэ.

Гарч буй нийтлэг зөрчлүүд:

- Цалинг багцаагаар тооцоолж 12 сараар бодож мэдүүлдэг, 1 сарын цалингаар мэдүүлдэг;
- Компанийн үйл ажиллагааны нийт орлого мэдүүлдэг;
- Тухайн жилд авсан зээлийг мэдүүлдэг;
- Байгууллагаас олгосон тусламжийн орлого мэдүүлдэггүй;
- Интернет худалдаа, сүлжээнээс олсон орлого мэдүүлдэггүй;
- Эд хөрөнгө худалдан борлуулсны орлого мэдүүлдэггүй.

■ Орон сууц, барилга, байгууламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

3.2.1. Орон сууц, барилга, байгууламж						
№	Орон сууц, барилга, байгууламжийн төрөл	Хийц, талбай	Байршил /хаяг/	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Бүртгэлийн гэрчилгээний дугаар	Эх үүсвэрийн тайлбар
1	Нийтийн орон сууц	Угсармал, 60 м2, 3 өрөө	Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот	80 000 000	Ү-2204689721	2012 онд эцэг М.Доржоос өв залгамжлалаар өвлөгдсөн. Өмчлөгч Д.Баяр
2	Авто гараж	Тоосгон, 12 м2	Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны дэргэд	10 000 000	Гэрчилгээ гараагүй	2005 онд 3 сая төгрөгөөр худалдаж авсан. Хьюндэй Соната II маркийн машин зарсан орлогоор авсан.

Тайлбар: “Орон сууц, барилга байгууламжийн төрөл” хэсэгт хувийн болон нийтийн орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга, автозогсоол, гараж, зуслангийн байр, гэр зэргийг мэдүүлнэ. “Хийц, талбай” баганад тухайн барилга байгууламжийн хийц, өрөөний тоо, талбайн хэмжээ, зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ. Гадаад улс, чөлөөт бүсэд байгаа орон сууц, барилга байгууламжийг мэдүүлнэ.

Гарч буй нийтлэг зөрчлүүд:

- **Төрөөс үнэгүй хувьчлагдсан орон сууцны хамтран өмчлөгчөөр бүртгэлтэйг мэдүүлдэггүй;**
- **Гэр бүлийн гишүүдийн өмчлөлийн орон сууц, барилга байгууламж мэдүүлдэггүй;**
- **Хөрөнгө оруулж захиалгаар бариулж буй орон сууц мэдүүлдэггүй;**
- **Орон сууцтай хамт авсан гэх тайлбартайгаар авто зогсоол мэдүүлдэггүй;**
- **Эх үүсвэрийг хангалттай тайлбарладаггүй;**
- **Газар дээр баригдсан хувийн сууц болон барилгыг мэдүүлдэггүй;**
- **Худалдсан орон сууцыг мэдүүлгийн уг хэсгээс хасалгүйгээр мэдүүлдэг;**

☐ Тээврийн хэрэгсэл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

3.2.2. Тээврийн хэрэгсэл					
№	Тээврийн хэрэгслийн төрөл, үйлдвэрлэсэн он	Тоо, ширхэг	Гэрчилгээ, улсын дугаар, эзэмшигчийн нэр	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Эх үүсвэрийн тайлбар
1	Тоёота Ключер, 2004 онд үйлдвэрлэгдсэн	1 ш	АЯ123456, УНП 12-34, Д.Болд	17 000 000	2010 онд 15 сая төгрөгөөр худалдаж авсан. Худалдаа хөгжлийн банкны хадгаламжаас 2 сая төгрөг, “ХХХ” ХХК-ын ногдол ашгаас 5 сая төгрөг, урьд нь хэрэглэж байсан Гранд Марк II маркийн УБӨ 23-45 дугаартай машиныг борлуулсан 8 сая төгрөгөөр эх үүсвэрийг бий болгосон.
2	Тоёота Приус, 2002 ондүйлдвэрлэгдсэн	1 ш	АЯ654321, УБП 34-56, О.Энхцэцэг	6 000 000	2009 онд 8 сая төгрөгөөр хадам эцэг, эх эхнэр О.Энхцэцэгт худалдаж авч өгсөн.
Нийт дүн				23 000 000	

Тайлбар: “Тээврийн хэрэгсэл” хэсэгт автомашин, өөрөө явагч хэрэгсэл, усан онгоц, нисэх онгоц, бусад техник, тоног төхөөрөмжийг мэдүүлнэ.

Гарч буй нийтлэг зөрчлүүд:

- Худалдсан тээврийн хэрэгслийн өмчлөл шилжүүлдэггүй;
- Ашиглахаа больсон тээврийн хэрэгсэл улсын бүртгэлээс хасуулдаггүй;
- Зээлээр авсан тээврийн хэрэгсэл мэдүүлдэггүй;
- Компанийн өмчлөлийн тээврийн хэрэгсэл мэдүүлсэн.

☐ Мал, аж ахуй байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

3.2.3 Мал, аж ахуй					
№	Төрөл	Тоо, толгой	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Эх үүсвэрийн тайлбар	Байршил
1	Хонь	126	11 340 000	Өвөө Н.Мягмараас 2000 онд тасалж өгсөн 20 хонь, төлөөр өссөн	Архангай аймгийн Их тамир суманд нагац ах М.Рагчаагийн байдаг
2	Ямаа	85	7 650 000	Өвөө Н.Мягмараас 2000 онд тасалж өгсөн 20 ямаа, төлөөр өссөн	Архангай аймгийн Их тамир суманд нагац ах М.Рагчаагийн байдаг
3	Адуу	19	5 700 000	Аав М.Доржоос 2005 онд 5 адуу тасалж өгсөн, 2007 онд Хэнтий аймгаас 3 унагатай гүүг 3 сая төгрөгийн хуримтлалын орлогоор худалдаж авсан, төлөөр өссөн.	Архангай аймгийн Их тамир суманд нагац ах М.Рагчаагийн байдаг
4	Хурдан удмын адуу	5	5 000 000	Найз нөхдөөс бэлэглэсэн.	Архангай аймгийн Их тамир суманд нагац ах М.Рагчаагийн байдаг
Нийт дүн		235	29 690 000		

Тайлбар: “Мал, аж ахуй” хэсэгт таван хошуу малаас гадна туслах аж ахуйн чиглэлээр үржүүлж байгаа гахай, тахиа, загас, зөгий бусад тэжээвэр амьтдыг мэдүүлнэ.

☐ Газар байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

3.2.4 Газар					
№	Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дугаар, он, сар, өдөр	Төрөл, хэмжээ	Байршил /бүс нутаг/, хаяг	Зах зээлийн үнэлгээ /төгрөг/	Эх үүсвэрийн тайлбар
1	ГД:987654, 2004.10.24-ны өдрийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын 358 дугаартай захирамжаар	Эзэмших эрхтэй, 0,04 га	Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо, Шарга морьт зуслан	--	Улсаас хууль ёсны дагуу үнэгүй авсан.
2	ГД:123456, 2008.12.19-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын 147 дугаартай захирамжаар	Өмчлөх эрхтэй, 0,07 га	Сонгино-Хайрхан дүүргийн 20 дугаар хороо, Тахилтын аманд	4 000 000	2008 онд цалин, хуримтлалын орлогоор 500 000 төгрөгөөр худалдаж авсан.
3	2006.10.24-ны өдрийн Баянгол дүүргийн Засаг даргын 322 дугаартай захирамжаар	Ашиглах эрхтэй, 12м2	Баянгол дүүргийн 5-р хороо 10-р хороолол 9А байрны дэргэд	--	Гэрээгээр түр ашиглаж байгаа
Нийт дүн				4 000 000	

Тайлбар: Мэдүүлэг гаргагчийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа болон ашиглаж байгаа газрыг мэдүүлнэ.

Газрын гэрчилгээ гараагүй газрыг эзэмшиж байгаа бол мэдүүлнэ.

☐ Үнэт эдлэл, урлагийн бүтээл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.5 Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйл				
№	Хөрөнгийн нэр	Үнэлгээ /төгрөг/	Эзэмшигчийн нэр	Эх үүсвэрийн болон бусад тайлбар
1	Шүрэн толгойтой халтар манан хөөрөг	20 000 000	Д.Баяр	Өвөө Н.Мягмараас 2003 онд өвлөж авсан.
2	Мөнгөн тоногтой хуучны эмээл хазаар	5 000 000	Б.Тэмүүлэн	Эцэг М.Доржоос хүү Б.Тэмүүлэнд 2012 онд өвлөгдсөн.
Нийт дүн		25 000 000		Эх үүсвэрийн тайлбар

Мэдүүлгийн дээрх хэсэгт: Виртуал хөрөнгө (криптовалют, койн, токен, NFT г.м.) –ийг мэдүүлнэ.

☐ Хадгаламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

3.2.6 Хадгаламж, бэлэн мөнгө, хувийн харилцах болон төлбөрийн данс, картны үлдэгдэл				
№	Банк, санхүүгийн байгууллагын нэр	Дүн төгрөг/	Эзэмшигчийн нэр	Эх үүсвэрийн тайлбар
1	Худалдаа хөгжлийн банкны хугацаатай хадгаламж	26 657 500	О.Энхцэцэг	2005 онд 3 сая төгрөгөөр хугацаагүй хадгаламжийн данс нээлгэсэн. Цалин, хуримтлалын орлого, хөрөнгө борлуулсны орлого, “ХХХ” ХХК-ийн ногдол ашгийг хадгалуулсан мөнгө
2	Худалдаа хөгжлийн банкны цалингийн карт	237 000	Д.Болд	Цалингийн орлого
3	Хаан банкин дахь хувийн харилцах данс	2 345 000	О.Энхцэцэг	Үйл ажиллагааны орлого, өдөр тутмын гүйлгээ хийгддэг.
4	Бэлэн мөнгө	680 000	О.Энхцэцэг, Д.Болд	Цалин, үйл ажиллагааны орлогын 2015.12.31-ны өдрийн үлдэгдэл дүн
	Нийт дүн	29 899 500		

Тайлбар: Энэ хэсэгт гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байгаа бүх төрлийн данс, картны үлдэгдлийг мэдүүлнэ.

Гарч буй нийтлэг зөрчлүүд:

- **Өмнөх оны 12 дугаа сарын 31-ний өдрийн байдлаар мэдүүлнэ;**
- **Зөвхөн хадгаламжнаас гадна цалингийн карт, харилцах дансны үлдэгдлийг мэдүүлнэ;**
- **Валютыг төгрөгт хөрвүүлж мэдүүлнэ;**

☐ Авлага байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

3.2.7 Авлага

№	Хувь хүн, хуулийн этгээдийн нэр	Дүн /төгрөг/	Хугацаа, хүү	Тайлбар
1	Д.Эрдэнэхуяг / иргэн/	22 500 000	-	2015 онд худалдан борлуулсан орон сууцны үлдэгдэл талбөр
2				
Нийт дүн		22 500 000		

☐ Зээл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

3.2.8 Зээл						
№	Зээлдүүлэгчийн нэр, хаяг	Анх авсан зээлийн хэмжээ /төгрөг/	Тухайн жилд зээл, зээлийн хүүд төлсөн дүн /төгрөг/	Зээл авсан, болон төлж дуусах огноо	Зориулалт	Зээлийн байрьцаа, батлан даагч
1	Орон сууц санхүүжилтийн корпораци	35 000 000	4 236 890	2021.07.20 - 2036.07.20	Орон сууц худалдан авах	Баянгол дүүргийн 5 дугаар хороо, Өнөр хотхоны 10 дугаар байрны 65 тоот
	Нийт дүн	35 000 000				

Тайлбар:Энэ хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн зээлийн талаарх мэдээллийг мэдүүлнэ.

Гарч буй нийтлэг зөрчлүүд:

- **Банкнаас бусад ББСБ, хадгаламжийн зээл, иргэнээс авсан зээл мэдүүлдэггүй;**
- **Тухайн жилд зээл, зээлийн хүүд төлсөн төлбөрийг үнэн зөв мэдүүлдэггүй;**
- **Төлж дууссан зээлийг зээлийн мэдээллээс хасдаггүй.**
- **Гар утасны апп-аас авсан зээл.**

▫ Хөрөнгө оруулалт байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.9 Компани, нөхөрлөл, хоршоонд оруулсан хөрөнгө оруулалт							
№	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр	Хувьцааны тоо	Нэгж хувьцааны үнэ /төгрөг/	Хувьцааг худалдаж авсан үнэ /төгрөг/	Хуулийн этгээдийн нийт дүрмийн сан /төгрөг/	Ногдол хувь	Эх үүсвэрийн тайлбар
1	“ХХХ” ХХК	1000 ш	-	-	1 000 000	100%	2016 онд эхнэрийн хамт үүсгэн байгуулсан. О.Энхцэцэг 50 хувийг, Д.Болд 50 хувийг тус тус эзэмшдэг. Дүрмийн санг мал зарсан орлогоор бүрдүүлсэн.
2	“Эрдэнэс таван толгой” ХК	4288 ш	-	-	-	-	Улсаас гэр бүлийн 4 гишүүнд үнэгүй өгсөн. Энгийн хувьцаа
3	“Эрдэнэс МГЛ” ХХК	4 ш	-	-	-	-	Улсаас гэр бүлийн 4 гишүүнд үнэгүй өгсөн. Давуу эрхийн хувьцаа
4	“Их дэлгүүр” ХК	148 ш	568	-	-	-	1991 онд цэнхэр тасалбараар улсаас үнэгүй өгсөн.
	Нийт дүн				1 000 000		

Тайлбар: Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн үүсгэн байгуулсан болон хувь нийлүүлсэн хуулийн этгээд, түүний толгой, охин, хараат болон салбар компани, аж ахуйн нэгж, гадаад, дотоодын хөрөнгийн биржээс худалдан авсан хувьцаа, бонд, бусад үнэт цаасыг мэдүүлнэ. Хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой бичнэ

Гарч буй нийтлэг зөрчлүүд:

- **Үйл ажиллагаа явуулдаггүй гэх тайлбартайгаар өөрийн бон гэр бүлийн гишүүдийн үүсгэн байгуулсан хуулийн этгээд мэдүүлдэггүй;**
- **Компани хамтран үүсгэн байгуулсан гишүүдийг мэдүүлгийн “Нэгдмэл сонирхолтой этгээд” хэсэгт мэдүүлдэггүй;**
- **Хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, захирлаар бүртгэлтэй байдаг.**

☐ Эрх, патент, тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй бол /-/ тэмдэглэгээ хийхс

3.2.10 Эрх, патент, тусгай зөвшөөрөл				
№	Төрөл	Эзэмшигчийн нэр	Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага, огноо	Тайлбар
1	Зохиогчийн эрх	Д.Болд	Оюуны өмчийн газар, 2020 он	“Ухаарлын хишиг” ном бичиж зохиогчийн эрх авсан.

Тайлбар: Өөрийн болон гэр бүлийн гишүүний өмчлөл, эзэмшилд байгаа зохиогчийн эрх, патент, тусгай зөвшөөрлийг мэдүүлнэ.

Мэдүүлгийг үнэн зөв мэдүүлсэн : Д.Болд / Д.Болд/
/ гарын үсэг / /гарын үсгийн тайлал/

2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр

ХАСХОМ-ийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай “БАТАЛГААНЫ МАЯГТ”

Жич: “Албан тушаал” гараас бичихгүй,
сонголтоос сонгож оруулах






ХАСХОМ-ийн зөрчлийн хариуцлага

АЭХ-ийн 13.8,
АСЗТХ-ийн 29.2



ХАСХОМ-ийг мэдүүлэхэд анхаарах зарим асуудал:



- Мэдүүлгийн гарчгийн болон томилогдсон огноо
- Мэдүүлэг гаргах үндэслэл
- Эх үүсвэрийн тайлбар ойлгомжгүй буюу хэт товчхон
- Хамаарал бүхий этгээдийг мэдүүлэх
- Гэр бүлийн гишүүдийн нэр дээрх хөрөнгө, орлогыг мэдүүлэх
- Хонжвор, хүүхдийн мөнгө, оюутны мөнгө г.м орлогыг мэдүүлэх
- Бэлэг, хандив, зээл гэх мэт жил тутамд өөрчлөгдөж байдаг орлого, хөрөнгө зээлийг давтан хуулж бичсэн эсэх.
- Компаний нэр дээр хөрөнгө, орлогыг мэдүүлсэн эсэх
- Цалин хөлсөө зөв мэдүүлсэн эсэх

ХАСХОМ-ийг мэдүүлэхэд анхаарах зарим асуудал:

- Их хэмжээний өөрчлөлтийг 30 хоногт нь мэдүүлсэн эсэх
- ХАСХОМ-ийн хөрөнгө, орлогын хэсгийг урьд оны хөрөнгө, орлогоо 12.31-ний байдлаар мэдүүлсэн эсэх
- Валютаар илэрхийлэгдэх орлого, хөрөнгийн мөнгөн дүнг Монгол банкны тухайн үеийн ханшаар хөрвүүлж мэдүүлдэггүй
- Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн нэр дээрх болон хөрөнгө оруулсан компаний талаарх мэдээллийг 3.2.9-т мэдүүлэх
- Бусадтай хамтран эзэмшиж, өмчилдөг хөрөнгө, орлого, зээлийг мэдүүлдэггүй;
- Данс, бэлэн мөнгөний үлдэгдлийг мэдүүлэх



- Үл хөдлөх эд хөрөнгөтэй эсэх лавлагаа
- Авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаа
- Зээлийн мэдээллийн лавлагаа
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын лавлагаа
- Газар эзэмших эрхийн лавлагаа
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт





АВАЛГАГҮЙ
НИЙГМИЙН
ТОЛОО
ХАМТААА

АВЛИГА МЭДЭЭЛЭХ УТАС
ЭНГЭЙН
ТАРХИАН **18001969**

ГОМДОЛ ӨГӨХ

ЭХЛЭЛ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ХАСХОМ ХАРАХ САНАЛ ОРУУЛАХ

Хайлтын нөхцөл

Эцэг/эх-ийн нэр: Байгууллага:

Нэр: Албан тушаал:

Тайлант он:

ХАЙХ

АРИЛГАХ

№	Тайлант он	Овог	Нэр	Байгууллага	Албан тушаал
1	2018	Баян	Энхцэцэг	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	Тасгийн дарга
2	2018	Баян	Мөнхжаргал	Зам, тээврийн хөгжлийн яам	Хэлтсийн дарга
3	2018	Баян	Амаржаргал	Эрүүл мэндийн яам	Газрын дарга
4	2018	Баян	Дашдэмбэрэл	Хөдөө Аж Ахуйн Их сургууль	Захирал
5	2018	Баян	Дашням	Золбоо	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам
6	2018	Баян	Бямбахишиг	Пүрэвсүрэн	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам
7	2018	Баян	Цэрэнлхам	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам	Ахлах нягтлан бодогч
8	2018	Баян	Энхтүвшин	Стандарт, хэмжил зүйн газар	Ерөнхий нягтлан бодогч
9	2018	Баян	Хүнбилэг	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	Эрүүл мэндийн даатгалын зарлага төлбөр тооцоо хариуцсан байцаагч
10	2018	Баян	Яабаатар	Эрдэнэс таван толгой ХК	Ахлах зөвлөх

2016 оны ХОМ	220
2017 оны ХОМ	239
2018 оны ХОМ	36409
2019 оны ХОМ	36794
2020 оны ХОМ	43692

Төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтийг мэдээлэл авах боломжоор хангах зорилгоор 2018 оноос эхлэн нийт мэдүүлэг гаргагчдын ХОМ-ийн хураангуйг тус газрын <http://www.xасxом.iaас.mn> цахим хуудсанд нээлттэй байршуулснаар иргэд мэдээлэлтэй танилцах, хяналт тавих нөхцөл байдал сайжирч байна.

ХОМ-ийг нээлттэй байршуулах

ЭБАТ-аас мэдүүлгийн бүртгэл, тайлан гаргах тухай



СИСТЕМЭЭС ТАЙЛАН ГАРГАХ

ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН СИСТЕМ

Нүүр хуудас Түгэлж ХАСХОМ тайлан ХАСХОМ ЭГЭТ ХАСХОН хяналт шалгалт ХАСХОН Улаан туг ХАСХОМ хяналт шалгалт Сонгуульд нэр дэвшигчээр хайх Судалгаа, шинжилгээ

ХАСХОМ-ийн хяналтын санбар: 0

Нийт мэдүүлэг гаргач 485

Шинэчилэн гаргасан 11936

Их хэмжээний өөрчлөлт 93

Баталгаажуул 0

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн жагсаал

Регистрийн дугаар	Овог	Нэр	Байгууллага	Албан тушаал	Он	Төлөв	Үйлдэл
1	Алтан	Алтан	ХАСХОМ-ийн хяналтын санбар	ХАСХОМ-ийн хяналтын санбар	2021*	✓	...
2	Алтан	Алтан	ХАСХОМ-ийн хяналтын санбар	ХАСХОМ-ийн хяналтын санбар	2021*	✗	...

Нүүр хуудас > ХАСХОМ тайлангууд

Байгууллага:

ХАСХОМ: --Сонго--

Тайлангийн төрөл: --Сонго--

Тайлант он: 2022

Тайлан үзэх Буцах

Нүүр хуудас > ХАСХОМ тайлангууд

Байгууллага: Төрийн албаны зөвлөл

ХАСХОМ: --Сонго--

Тайлангийн төрөл:

Тайлант он: --Сонго--

- ХАСХОМ 1
- ХОМ-хураангуй
- ХАСХОМ 3
- ХАСХОМ 4
- ХАС-хураангуй

Нүүр хуудас > ХАСХОМ тайлангууд

Байгууллага: Төрийн албаны зөвлөл

ХАСХОМ: --Сонго--

Тайлангийн төрөл: --Сонго--

Тайлант он:

--Сонго--

Байгууллагын хэмжээнд

Харьяа байгууллага

Нүүр хуудас > ХАСХОМ тайлангууд

Байгууллага:

ХАСХОМ: --Сонго--

Тайлангийн төрөл: --Сонго--

Тайлант он: 2022

Тайлан үзэх Буцах

Тайлан үзэх



ШУДАРГА ЁС,
ХӨГЖИЛ
ДЭВШИЛД

Вэб сайт:

<https://www.iaac.mn/>

<https://meduuleg.iaac.mn/>

<http://хасхон.iaac.mn/>

утас: 70112489, 70110252

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА



**ДЭЛХИЙ НИЙТЭЭРЭЭ
АВЛИГЫН ЭСРЭГ
НЭГДЬЕ**

МОНГОЛЫН АВАЛГАНЫ ТЭГШЛЭЛТ

ХАМААРАЛ БҮХИЙ ЭТГЭЭД:



3.1.5§ “**хамаарал бүхий этгээд**” гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;

НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД



3.1.6§ **"нэгдмэл сонирхолтой этгээд"** гэж тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг;